# ДАРХАН-УУЛ АЙМАГ ХОНГОР СУМЫН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ХАМТАРСАН БАГИЙН МЭДЭЭЛЭЛ

2019 он

http://khongor.darkhan-uul.khural.mn

Хонгор Сум Буурал

# Хамтарсаг багийн бүтэц бүрэлдэхүүн

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор сумын гэр бүлийн хүчирхийлэлэй тэмцэх хамтарсан баг нь 10 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр батлагдан хамтарсан багийн үйлчилгээг үзүүлж байна.

Хамтарсан багийн дарга-сумын Засаг дарга

- ❖Нарийн бичгийн дарга-сумын Нийгмийн ажилтан
- ❖ 1-р багийн Засаг дарга
- ❖2-р багийн Засаг дарга
- ❖ 3-р багийн Засаг дарга
- ❖Сумын хэсгийн төлөөлөгч
- ❖Эрүүл мэндийн төвийн НЭМ-ын ажилтан
- ❖11-р сургуулийн нийгмийн ажилтан
- ❖14-р сургуулийн нийгмийн ажилтан

# Хамтарсан багийн зорилго

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан нөхцлийг арилган хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх , таслан зогсоох нь гэр бүлийн амгалан тайван байдал хангагдан, хүүхдийн эрхийг дээдэлсэн өрх иргэнтэй сум болох.

# Кейс шийдвэрлэлт

- Сумын хэмжээнд 2019 оны 10 сарын байдлаар 9 дуудлага мэдээлэл ирж хамтарсан багаар хэлэлцэн, холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл – 7
- ХТУ-108 утсанд дуудлаг мэдээлэл - 2

# Хамтарсан багт ирсэн дуудлага мэдээлэл



# Хонгор сум –Хамтарсан баг




http://khongor.darkhan-uul.khural.mn

Хонгор Сум Буурал

## Урьчилан сэргийлэх нөлөөллийн чиглэлээр

- Судалгаан дээр үндэслэн архины хамааралтай 15 иргэн, гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг 22 иргэний ар гэрт зочилон архины хорт зуршил, үйлдэгдэж болох гэмт хэрэг зөрчлүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Хорих ангиас суллагдсан 7 иргэнтэй ганцаарчилсан ярилцлага хийиж зөвөлгөө мэдээлэл өгч халамжийн үйлчилгээнд хамруулах өргөдөлийг хүлээн авч холбон зуучилсан. Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй 18 хүүхдэд цагдаагийн ажилтан, 11,14-р сургуулийн нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ийн мэргэжилтэнтэй хамтран ганцаарчилсан уулзалт ярилцлагыг хийсэн.

## Урьчилан сэргийлэх нөлөөллийн чиглэлээр

- Салхит багт хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Төмөр замын цагдаатай хамтран галт тэрэгний буудал орчмоор гэл тэрэгний цагийн хуваарын дагуу /10 цаг 20 минутаас 10цаг 40 минут , 16 цаг 20 минутаас 16 цаг 30 минут багш, ажилтан албан хаагч нар эргүүлд гарч , галт тэрэгний буудал түүний орчинд зөрчилд холбогдох , хэв журам алдагдах , хүүхдийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

# Сургалт сурталчилгааны чиглэлээр

"ХҮҮХДИЙГ ЗОДОЖ ШИЙТГЭХГҮЙ БАЙХ " өдрийг тохиолдуулан хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох, зодож шийтгэлгүйгээр хүмүүжүүлэх, хүүхдийн бие махбодь, сэтгэл санааны шийтгэлийг таслан зогсоохын чухлыг олон нийтэд ойлгуулах, хүмүүжлийн эерэг аргуудыг сурталчлан таниулах ажлыг сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, 11, 14 дүгээр сургууль, 16 дугаар цэцэрлэг, УБТЗ-ын Салхит зангилааны харъяа байгууллагуудад зохион байгууллаа. Тус өдөрлөгт нийт 250 гаруй сураг, 235 эцэг, эхчүүд хамрагдаж 500 гаруй боршур тарааж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.



## Сургалт сурталчилгааны чиглэлээр

“Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай хуул” “Хүүхэд хамгааллын тухай ” “Зөрчлийн тухай хууль”-уудаар 4 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 424 иргэнийг хамруулсан.



# Судалгааны чиглэлээр

| № | Судалгааны нэр төрөл | Тоо |
|---|---|---|
| 1 | Архины хамааралтай иргэд | 15 |
| 2 | Гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг иргэд | 22 |
| 3 | Хорих ангиас суллагдсан иргэд | 7 |
| 4 | Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй иргэд | 34 |
| 5 | Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд | 18 |
| 6 | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, зөрчил гаргасан иргэдийн судалгаа | 7 |

# Дархан-Уул аймгийн Хонгор сум “статистик үзүүлэлт”

| № | Сонгосон үзүүлэлт | Хүн амын тоо |
|---|---|---|
| 1 | Нийт хүн ам | 6089 |
| 2 | Өрхийн тоо | 1609 |
| 3 | Шинээр төрсөн хүүхдийн тоо | 138 |
| 4 | 0-17 насны нийт хүүхдийн тоо | 2026 |
| 5 | 0-5 насны нийт хүүхдийн тоо | 758 |
| 6 | 6-17 насны нийт хүүхдийн тоо | 1268 |
| 7 | Бүтэн өнчин хүүхдийн тоо | 9 |
| 8 | Хагас өнчин хүүхдийн тоо | 98 |
| 9 | ЕБСургуульд хамрагдаж буй хүүхдийн тоо | 678 |
| 10 | Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо | 152 |
| 11 | СӨБ, Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо | 259 |
| 12 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | 36 |

*http://khongor.darkhan-uul.khural.mn*

*Хонгор Сум Буурал*

# Хамтарсан багийг чадвахжуулах сургалтанд хамрагдсан байдал

Хүчирхийллийн эсрэг үндэсний эсрэг төв, Щвейцарийн хөгжлийн агентлаг, ГБХЗХГазартай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтэнгүүдийн үйлчилгээ үзүүлэх чадамжийг бэхжүүлэх нь” сэдэв сургалт зохион байгуулагдаж сумаас хамтарсан багийн гишүүд болох 1,2,3-багийн засаг дарга, нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын мэргэжилтэн нар оролцсон.



# Үр дүн

- Дээрх хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд: сургалт суртчилгаа мэдээлэлийн ажил хийснээр иргэд хууль эрх зүйн мэдлэг мэдээлэлтэй болсон. Үүнээс үүдэлтэйгээр өөрийгөө болон бусдыг эрх зүйн байдлыг дээрдүүлсэн мөн холбогдох шатны байгууллагад мэдээлэлдэг болсноороо гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт сайжирхад нөлөөлсөн. Иргэдийн мэдээлэх байдал нэмэгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрүүл мэнд,амь насанд ноцтой хохирол учирч болхуйц байдлаас урьчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаа.

- Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй иргэд, хүүхэдтэй ганцаарчилсан ярилцлага  хийх, гэр бүлд нь зочилж мэдээлэл зөвлөгөө өгсөн нь иргэдийн гэр бүлдээ хандах хандлага, өөрийн байр суурийг үнэлэх үнэлэмж нэмэгдэхэд үр дүнтэй ажил болсон.



# Тайван амгалан гэр бүлд хүүхэд бүхэн жаргалтай

http://khongor.darkhan-uul.khural.mn

Хонгор Сум Буурал